

The Defacto Gazette

Мэдээлнэ. Зоригжуулна. Мэдэлжүүлнэ.

АГУУЛГА ▾

МОНГОЛ, АНГЛИ ХЭЛ ДЭЭР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН NO. 18 ЛХАГВА, 2017.10.25 WWW.DEFACTO.MN



Гэрэл зургийг cityinfo.mn

Таны цалингаар зөвхөн та, таны гэр бүл биш, бас төр засаг амьдардаг. Монголд татвараа хувь хүн өөрөө төлдөг болчихвол зан үйлд нь өөрчлөлт орж, төр засагтаа илүү хяналт тавьж, шахаж шаарддаг болно, Хуудас 1



INFORMING. INSPIRING. EMPOWERING.



Гар утасны аппликэйшн, Jargal Defacto

НИЙТЛЭЛ

- 1 Зан үйлийн эдийн засаг
- 4 Үндсэн хуульт, энэрэнгүй ёсыг хэн сэргээх вэ?

ЯРИЛЦЛАГА

- 3 Л.Мөнхзул
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого төлөвлөлтийн газрын дарга

ТОЙМ

- 5 Ядуурлын түвшин өсчээ
У И Х – А Р З Г – Ы Н
ГИШҮҮДИЙГ БАТАЛЛАА
Ерөнхийлөгч Х.БАТТУЛГА



Л.Мөнхзул

/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого төлөвлөлтийн газрын дарга/

“Эмэгтэй хүн өнөөдөр 25 жил шимтгэл төлөөд 24 орчим жил тэтгэвэр авч байгаа юм, гэтэл энэ нь тэр 25 жил ажиллаж байгаа хүний буруу бас биш, ажилламаар байна, ажлын байр алга” Хуудас 3



Гэрэл зургийг undesten.mn

Нэг хүний нэг сард амьжиргааны наад захын хэрэглээний зардал нь 146 мянган төгрөгөөс бага байгаа бол тэр хүнийг ядуу гэж үздэг, Хуудас 5



Гэрэл зургийг news.mn

МУ 2012 оноос цаазын ялаас түдгэлзсэн бөгөөд 2015 онд батлагдаж 2017 оны 7 сарын 01 – нээс хэрэгжиж эхэлсэн эрүүгийн хуулиар цаазын ял гэсэн ялын төрлийг хассан, Хуудас 6

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦИН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонбаярын Наранцацрал
Өсөхбаярын Биндэръяа
Адьяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ:

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976-94109342
🌐 www.defacto.mn



№402

Д.Жаргалсайхан

Долоо хоног бүрийн нийтлэл, jargaldefacto.com/category/23

Зан үйлийн эдийн засаг

Таны цалингаар зөвхөн та, таны гэр бүл биш, бас төр засаг амьдардаг.

Цалингийн тань II хувийг ажил олгогчоос, бас 10 хувийг танаас нийгмийн даатгалын шимтгэлд, дээр нь таны хэсгийг хассаны 10 хувийг (бас 7000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлээд) хувь хүний орлогын албан татвар гэж төр албадан авдаг. Та хэрвээ улсын дундаж цалин болох 950 мянган төгрөг сард авдаг бол гар дээрээ 776.5 мянга, төр танаас 173.5 мянгыг, ажил олгогчоос чинь 104.5 мянган төгрөг авдаг. Таны цалинг 950 мянга гэж байгаа ч, яг үнэндээ 1.054 сая, учир нь тийм мөнгө ажил олгогчоос гардаг бөгөөд дөрөвний нэгийг нь төр авчихдаг гэсэн үг.

Цалингийн дөрөвний нэгийн мөрөөр

Харин тэрхүү дөрөвний нэгээр нь төр засаг юу хийдэг болохыг хүн бүр мэддэггүй, сонирхдоггүй. Яагаад гэвэл татвар нэртэй энэ мөнгийг та өөрөө биш, таныг ажилд авсан хүн төлдөг. Харин өндөр хөгжсөн орнуудад хувь хүн өөрөө шууд төлдөг. Тийм ч учраас нийгмийн яг ямар даатгалд хэдий хэмжээний шимтгэл, тэтгэврийн сандаа хэдэн төгрөг хуримтлуулж буйгаа хүн бүр мэддэг, тохирсон үйлчилгээг хариуд нь шаарддаг. Хүсвэл хувийн эрүүл мэндийн болон тэтгэврийн санд бас даатгуулж, эрсдлээ илүү хамгаалуулдаг.

Монголд татвараа хувь хүн өөрөө төлдөг болчихвол зан үйлд нь өөрчлөлт орж, төр засагтаа илүү хяналт тавьж, шахаж шаарддаг болно.

Төрийн хариуцлага нэмэгдэж, үрэлгэн зардлаа хумиж, авлига хээл хахууль багасна. Ашиггүй ажиллаж, татварын мөнгөөр алдагдлаа нөхөж буй төрийн өмчийн компаниуд дампуурч, эсвэл хувьчлагдаж таарна. Товчоор, төрийн нэртэй хэний ч биш газар, өмч эзэнтэй болно. Засаглал сайжирч, эдийн засаг сэргэнэ.

Хүний зан үйлээр дамжин эдийн засагт томоохон нөлөө бий болдог тухай эрдэмтэд олон төрлийн судалгаа хийсэн бөгөөд зан үйлийн эдийн засаг гэж сэтгэл зүйн болон эдийн засгийн шинжлэх ухааны уулзвар дээр шинэ онол бий болов.

Зан үйлийн эдийн засаг (Behavioural Economics)

2002 оны эдийн засгийн ухааны Нобелийн шагналыг АНУ-н сэтгэлзүйч (психолог) Д.Канэманд олгожээ. Эдийн засгийн гол

том урсгалын төлөөлөл болох неоклассик онолчид хүн үргэлж рациональ (ухаалаг) шийдвэр гаргадаг гэж үздэг бол зан үйлийн эдийн засагчид хүний шийдвэрт сэтгэлзүйн хүчин зүйл давуу нөлөөлдөг, шийдвэр нь үргэлж ухаалаг байдаггүй гэж үздэг.

2017 оны Нобелийн шагналыг мөн зан үйлийн эдийн засагч Р.Тэйлер саяхан хүртэв. Түүний бичсэн "Misbehaving: The making of behavioral Economics" (Төрхгүйтэл: Зан үйлийн эдийн засгийг бүтээх нь) номонд хүний зан үйл нь эдийн засагт нөлөөлдгийг баталжээ.

Хүн жишээ нь яг адилхан хоёр юмыг өөрийн эрх мэдэлд байгаа бол байхгүйгээс нь илүү үнэлдэг болохыг тогтоожээ. Мөн өөрт нь хэрэгтэй ч, өндөр үнэтэй зүйлийг шударга биш гэж үзвэл худалдан авдаггүй гэжээ. Бас хэрэв цалингаасаа тодорхой хувийг нь хадгаламжийн данс руугаа шилжүүлдэг болчихвол тэр хадгаламжиндаа бараг хүрдэггүй гэнэ. Харин бүх цалингаа гар дээрээ авдаг хүн бүгдийг нь дуустал үрэх магадлал өндөр ажээ.

Энэ онолоор бол манай жишээн дэх хувь хүн цалингаа бүгдийг нь эхэлж өөрөө аваад, эрүүл мэнд, тэтгэвэр гэх мэт нийгмийн даатгалын шимтгэл болон орлогын татвараа мөн өөрөө биеллэн төлдөг болчихвол цалингийнхаа тэрхүү дөрөвний нэгийг илүүтэй үнэлж, түүний зарцуулалтад нь илүү санаа зовж, хяналт тавих юм.

Энэхүү зан үйлийн өөрчлөлт нь өнөөгийн монголын ардчиллыг хөгжүүлэхэд дутагдаж буй иргэдийн оролцоог хангах, иргэний нийгмийг бүрдүүлэхэд хувьсгалт өөрчлөлт хийх болно.

Иргэд төрөө сонгосон шигээ бүрэн дүүрэн хянаж чадвал, эдийн засгийн үргүй зардал багасч, чөлөөт зах зээлийг хөгжүүлэх саадыг арилгаж, хүн бүр эдийн засагт оролцох боломжийг тэлж, ажилтай болж ядуурлаас гарах үндсэн хаалга нээгдэх болно.

Иргэний нийгэм нь өндөр хөгжсөн улс оронд хүмүүс нь төр засгийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог, хэрэгжилтийг нь хянадаг, хариуцлага тооцдог. Харин манайд иргэний нийгэм идэвхтэй биш, нийтийн засаглалд иргэд хяналт тавихгүй байгаа учир улс төрчдөд төрөөр дамжуулан бизнес хийх, хувьдаа ашиг олох, нийтийн хөрөнгийг зувчуулан баяжих таатай хөрс арилахгүй байна.

2017.10.25





ДЕФАКТО ЯРИЛЦЛАГА

Англи, монгол хэл дээрх ярилцлага, jargaldefacto.com/category/8

Л.Мөнхзул
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бодлого
төлөвлөлтийн газрын дарга

Ж: Монгол улсын нийгмийн хамгааллын системийн бүтцийн тухай ярья. Нэгдсэн сантай, дотроо 5 сантай гэж байгаа. Эдгээр нь хэр том сан байдаг юм бол? Хэмжээ нь дотоодынхоо эдийн засаг, хөдөлмөрийн хүчтэй харьцуулахад ямар байдаг талаар хэлж өгөөч.

Л. Мөнхзул: Монгол улсын нийт хүн амын хөдөлмөрийн насны хүн ам эдийн засгийн идэвхтэй хүн амтай харьцуулахад 78 орчим хувь нь нийгмийн даатгалын шимтгэлд албан журмын болон сайн дурын журмаар даатгуулчихсан байгаа. Үндсэндээ 850 мянга орчим албан журмын даатгуулагч 2016 оны байдлаар бүртгэгдсэн байна. Харин 230 мянга орчим сайн дурын даатгуулагч бүртгэгдсэн байна. Эдгээрт эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоог оруулаагүй байгаа. Эрүүл мэндийн даатгалд 2,5 сая орчим хүн даатгуулсан. Манай систем өөрөө 5 төрлийн даатгалаас бүрдэж байна: тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн ослын болон ажилгүйдлийн даатгал.

Ж: Хоёулаа энэ дотроос хамгийн том нь болох тэтгэврийн даатгалын тухай эхлээд ярья. Тэтгэврийн даатгалыг цалингаас нь авах ёстой байдаг юм уу, өөрсдөө төлөх ёстой юм уу? Хэдэн хувийг цалингаас татах ёстой юм, хэд байсан юм бэ?

Л. Мөнхзул: Одоо манай даатгуулагчид тэтгэврийн даатгалд цалингаасаа 14 хувийн шимтгэл төлдөг. Өөрөөр хэлбэл хүн амын орлогын албан татвар төлөхөөсөө өмнө тухайн даатгуулагчийн авч байгаа нэгдсэн цалингийн 14 хувь нь тэтгэврийн даатгалын шимтгэлд явдаг. Үүний 7 хувийг нь хувь хүн өөрийн цалингаасаа, 7 хувийг нь ажил олгогч төлдөг. Энэ хувь хэмжээ 2009 оныг хүртэл 19 хувь байсан. Ажил олгогч 13,5 хувийг, даатгуулагч 5,5 хувийг төлдөг байсан. Энэ харьцааг 4:10-ын татварын бодлого гэсэн нэгдсэн бодлогын хүрээнд 2009

оноос бууруулсан.

Ж: Ингэснээр ямар эерэг тал гарсан бэ?

Л. Мөнхзул: Эерэг тал нь ажил олгогчдын хувьд татварын дарамтаас гарах боломж гарч ирсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ буурна гэдэг нь ажил олгогчдод мэдээж таатай зүйл. Нөгөө талаас болсон үйл явдал нь юу вэ гэхээр манайд өнөөдөр тэтгэврийн даатгалын санг шимтгэлээс цуглуулж ирсэн орлогоороо 60 хувийг нь төлдөг, 40 хувийг нь улсын төсвийн татаасаар төлдөг. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын шимтгэл болгож мөнгө төлөхгүй байгаа боловч аж ахуйн орлогын албан татвар, хүн амын орлогын албан татварын төлж байгаа хөрөнгийн томоохон хувь нь тэтгэврийн даатгалын санд татаас болж очиж байна гэсэн үг.

Ж: Энэ хоёр талтай л даа. Нэг талаас цалингийн татварыг багасгахаар олон хүмүүст ажил олгох боломж нээгдэнэ. Нөгөө талаасаа авсан мөнгөөрөө юу хийсэн бэ, ялангуяа урд өмнө нь засгийн газар юу хийсэн гэдэгтэй холбогдоно. Төр засаг юу хийсэн бэ гэхээр хүмүүс тэтгэврийн санд мөнгө төлөөд тэр нь тусдаа байх ёстой байсан юмыг олон арван жилийн туршид төсөвтэйгөө холиод яваад байдаг байсан. МҮЭХ-ны дарга асан С.Ганбаатар шаардахад төр хичнээн хэмжээний өртэй болж гарсан билээ?

Л. Мөнхзул: Энэ асуудал миний санаж байгаагаар 2011 он байсан байх. 2009–2010 оны үед юу гэж тохиролцсон бэ гэхээр 1995 онд тэтгэврийн даатгалын системд шилжихээс өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийг улсын төсвөөс хариуцна гэсэн хуулийн зүйл заалт гаргачихсан. 1995 оноос хойш шимтгэлийн орлого төвлөрүүлээд 1995 оноос хойш тэтгэвэрт гарсан хүмүүсийнхээ тэтгэврийг өгөөд байхаар сан хэсэг хугацаанд тодорхой хэмжээний

эерэг үлдэгдэлтэй явсан. Энэ эерэг үлдэгдлээс зарим тохиолдолд улсын төсвийн хариуцах ёстой иргэдийнхээ тэтгэврийг төлөөгүйн улмаас өр, авлага үүссэн байдаг. Энэ өр авлагыг тухайн үед тооцоод 236,5 тэрбум төгрөг байна гэж 2011 онд гаргаж ирж байсан. 2016 онд энэ 236,5 тэрбум төгрөгөө улсын төсвөөс тэтгэврийн сандаа өгөөд дууссан. Улс төлөх ёстой байсан өр төлбөрөө барагдуулсан, бид авлагаа аваад дууссан гэж ойлгож болно.

Хоёрдугаарт, нэг асуудал байдаг нь нэрийн дансны даатгуулагч буюу 2000 оноос эхлээд 1960 оноос хойш төрсөн даатгуулагчийг нэрийн дансны тогтолцоонд шилжүүлсэн. Үндсэндээ санхүүжилтийн механизм нь хэвээр үлдсэн, харин даатгуулагчийн орж ирсэн шимтгэлийг нэр дээр нь бүртгэдэг болсон. Нэр дээр нь ямар цалингаас хэдийг төлөх гэдэг нь бүртгэгддэг, буцаад нийгмийн даатгалын байгууллага цалингийн өсөлтөд үндэслэж хүү боддог болсон. Ингээд тухайн даатгуулагчийг тэтгэвэрт гарах үед нь цаашдаа амьдрах хугацаанд нь тооцож тэр хэмжээгээр тэтгэвэр нь тогтоогдох аргачлал руу шилжсэн.

Ж: 1960 онд төрсөн хүн байлаа гэхэд тэр хүн улсад төлсөн бүх мөнгөө авч байх хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр дунджаар нэг хүн хэдэн төгрөг төлсөн байдаг вэ?

Л. Мөнхзул: Тогтолцооны хувьд манай тэтгэврийн системд тулгараад байгаа асуудал нь яагаад тэтгэврийн шинэтгэл хийх болоод нас шинэчлэх асуудлууд хөндөгдөөд байна вэ гэдэг асуудал тавигдаж байгаа юм. Энэ бол үндсэндээ бидний системээс олгож байгаа тэтгэвэр нь эргээд хүний нийгмийн хамгааллыг хангаж чадахуйц түвшинд байна уу гэдэг л асуудал байгаа юм. Жишээ нь, 2015 онд 55 нас хүрч байгаа улсад 25 жил багшаар ажилласан 60 настай эмэгтэй байлаа гэж үзье. Бид нар хэд хэдэн ийм бодит жишээн дээр

тооцоолол хийж байсан л даа. Яг нэрийн дансандаа төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тооцоод үзэхээр тэтгэвэр нь маш бага гарч ирээд байдаг. Харин 1995 оны хуулиар авч байсан цалингийн хувиар тооцохоор өндөр гарч ирдэг. 1995 оны хуулиар 25 жил ажилласан хүн авч байсан дундаж цалингийнхаа 52,5 хувиар тэтгэвэр тогтоолгох ёстой. Үүнд ямар шалтгаан байгааг эдийн засагч, шүүмжлэгч нар тайлбарлахдаа: “Аргагүй шүү дээ, улс энэ мөнгийг нь аваад хөрөнгө оруулалтанд хийж өсгөж арвижуулаагүй шүү дээ” гэж факт гаргаж ирдэг. Харамсалтай нь энэ бол бодит зүйл биш, яагаад гэвэл үүнд хэдэн хүчин зүйлс нөлөөлж байгаа юм. Нэгдүгээрт, 1995 оноос хойш тухайн даатгуулагчийн нэр дээр бичсэн мөнгөнд бодсон хүүг нь аваад үзэхээр хамгийн өндөртөө 26 хувь, хамгийн багадаа 12 хувь байдаг. Өөрөөр хэлбэл даатгуулагчийн нэрийн дансанд төвлөрч байгаа мөнгийг жилд 12–24 хувийн хүүгээр өсгөөд явахад тэр хүн ирээдүйд бага тэтгэвэр аваад байна. Энэ нь цалингийн системтэй мөн холбогдож байгаа асуудал. 2000 онд байсан дундаж цалин 2015 оны цалингаас маш өөр байгаа юм.

Ж: Цалингийн систем ямар байх нь хамаагүй миний өгсөн мөнгийг буцаагаад өгөх ёстой шүү дээ.

Л. Мөнхзул: 2000 онд жишээлбэл дундаж цалин 200 мянган төгрөг байсан гэж бодоход тухайн үеийн дундаж хүүгээр нь бодоод нэрлэсэн цалин руу нь татаад хүүгээ тухайн жилийнхээ эдийн засгийн өсөлтөөр өсгөдөг.

Ж: Тэр өссөн мөнгө тэгээд хаачсан байж таарах уу? Ямар тооцоолол энэ хорвоо дээр гарч ирээд нэг хүний өгсөн мөнгийг өсгөж байгаад буцаагаад “жижигхэн” болгоод өгч байна вэ?

Л. Мөнхзул: Тэгж ойлгож болохгүй. Жишээлбэл 2000 онд тухайн хүн тэтгэвэртээ жилдээ 100 мянган төгрөг төлөөд явж байжээ гэж бодъё. Үүнийг 2000 оны дундаж цалингийн өсөлтөөр бодоод үзэхэд 26 хувь гарч ирж байна. Тэгэхээр 200 мянган төгрөгийг бид 26 хувь өсгөлөө, энэ өссөн дүн дээр дараагийн жил мөн 25 хувийн хүүгээр өсгөнө гэх мэт тухайн даатгуулагчийн парадокс нь яагаад бид өндөр хүү бодож өгч байхад бага тэтгэвэртэй гарч байна вэ гэхээр хэд хэдэн шалтгаан байна. Нэгдүгээрт, 1995 оноос өмнөх ажилласан хугацааны эхний үлдэгдэл тооцоход бодит цалингийн мэдээлэл

маш дутуу байдаг. 1960 онд төрсөн хүн гэхэд жишээлбэл 1995 онд 35 настай, 35 нас хүртлээ магадгүй 10 гаруй жил шимтгэл төлчихсөн хэрэг их байдаг. Үүнийг хийсвэрээр тооцоолж гаргах хэрэг гардаг гэсэн үг. Яагаад гэвэл 1995 оноос өмнө цаасан баримт бичгээр авдаг байсан юм байна лээ.

Ж: Тэр байна уу, байна. Гэтэл яагаад тэр баримт бичиг алга болчихдог билээ?

Л. Мөнхзул: Тэр баримт бичиг бол алга болоогүй байгаа. 1995 оны цаасан баримтан дээр үндэслэж өнөөгийн үнэ цэнэд хөрвүүлж тооцож байгаа. Тэгэхээр энэ дээр тооцооны асуудлыг залруулж, эхний үлдэгдлийг тооцох асуудлыг анхаарах ёстой байдаг. Хоёрдугаарт, манай систем маань өөрөө даатгуулагчийг аль болох цөөн жил даатгуулаад тэтгэврээ эрт тогтоолгох нь ашигтай нөхцөл байдал үүсдэг учраас хүмүүс эртхэн тэтгэврээ тогтоолгоод тэтгэвэр, цалин хоёроо зэрэг аваад явбал хувь хүнд ашигтай. Хэдийгээр хүмүүс 35 жил хөдөлмөр эрхэлж байгаа боловч яг нийгмийн даатгалын шимтгэлээ 25 жил төлсөн байдаг гэх мэт. Үндсэндээ хувь нэмэр оруулж байгаа дундаж хэмжээ социализмын үеэс буурсан байгаа. Хүмүүс тогтвортой олон жил шимтгэл төлж чадахгүй байна.

Ж: Яагаад тэр вэ?

Л. Мөнхзул: Түрүүн хэлсэнчлэн тэтгэврийн хууль маань хүнийг олон жил шимтгэл төлөхийг урамшуулж чадахгүй байна. Олон жил тэтгэвэр төлөх тусмаа их тэтгэвэр авах нь алдагдсан нөхцөл байдал гарч ирээд байгаа учраас үүнийг бид залруулах ёстой юм. Тэтгэвэр бол ямар цалин хөлс авч байсны илрэл болдог. Авч байгаа цалингаасаа л шимтгэл төлдөг, тодорхой хадгаламж үүсгэдэг учраас. Тэгэхээр хэт бага цалингаас хэт бага хадгаламж үүсээд, хэчнээн өндөр хүүгээр өсгөсөн ч дундаж наслалттайгаа харьцуулахад олон жил их хэмжээний тэтгэвэр авч чадахгүй байна.

Ж: Цалингаараа сайхан амьдарна гэдэг чинь улс төрийн намуудын програмд л байдаг байх, жинхэнэ амьдрал дээр байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой асуудал. Хөдөлмөрийн бүтээмжийг өсгөхийн тулд ямар концесс байх ёстой гэж та үздэг вэ? Та их сургуульд эдийн засгийн мэргэжлээр төгссөн, Австралид Сиднейгийн их

сургуульд санхүүгийн менежментээр магистраа хамгаалаад ирсэн хүн энэ талаар бэлтгэгдсэн боловсон хүчний нэг гэж би ойлгож байгаа. Ялангуяа зах зээлийн эдийн засагт тэтгэврийн сан нээхийг оролдож байгаа энэ үед тэтгэврийн сангийн шинэчлэл хийх тухай хуулийн төслийг боловсруулахад оролцсон байна лээ. Макро зургаар нь харахад хамгийн чухал асуудал нь юу вэ?

Л. Мөнхзул: Зардал өндөртэй, бүтээмж багатай тохиолдолд цалинг өсгөх нь аж ахуй нэгжүүдийн хувьд боломж багатай. Цалин бага байхаар хуримтлуулах юм нь бага, буцаад тэтгэвэр нь бага болчихож байгаа юм. Гэтэл тэр хүн 35 жил хөдөлмөрлөсөн нь үнэн, ард нь хүн би яагаад 35 жилийн туршид төлөх ёстой үүргээ төлсөн байхад амьжиргааны түвшин хангагдахгүй байна вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм.

Тэгэхээр эдийн засгийн бууралтын үзэгдэл бодит цалингийн бууралтанд буцаад 20–30 жилийн дараа хувь хүний тэтгэвэрт нөлөөлөөд эхэлдэг.

Мөн тэтгэврийн системийг тойрсон улс төржсөн шийдвэрүүд тэтгэврийн системийг маш тогтворгүй болгодог. Ер нь тэтгэврийн системд ямар асуудал үүсээд байна вэ гэхээр ирээдүйн хүн ам зүйн бүтэц харьцаанд өөрчлөлт гараад байна. Манай тэтгэврийн мэдээллийн бааз дээрээс харахад эмэгтэй хүн өнөөдөр 25 жил шимтгэл төлөөд 24 орчим жил тэтгэвэр авч байгаа юм, тэгэхээр тухайн хүний амьдралын идэвхтэй болон идэвхгүй үе нь ойролцоо болоод ирж байна. Цаашдаа энэ харьцааг бид нар яаж өсгөх вэ? Гэтэл энэ нь тэр 25 жил ажиллаж байгаа хүний буруу бас биш, ажилламаар байна, ажлын байр алга.

Эдийн засаг, цалингийн, бүтээмжийн өөрчлөлт нь бас тэтгэврийн бодлогод нөлөөлж байгаа. Бид зөвхөн нас, шимтгэлийг өсгөснөөрөө хүний тэтгэврийг өсгөх хэцүү, энэ бол олон жилийн тогтвортой бодлогын үр дүнд илэрдэг. Өндөр хөгжилтэй улс орнууд ч гэсэн тэтгэврийн шинэчлэл хийгээд төдийлөн амжилт олдоггүй. Эхний ээлжинд насаа өсгөж, шимтгэлээ өсгөх бодлого баримталдаг. Хэрвээ шимтгэлийн хэмжээг өсгөөд тэтгэврээ тавьж чадахгүй бол өөр эх үүсвэрүүдийг хайх жишээ бусад орнуудад ч гэсэн гарч байгаа юм.

2017.09.23

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/l-munkhul-munkhul-lkhagvasuren> холбоосор үзнэ үү.



Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн
доктор

Үндсэн хуульт, энэрэнгүй ёсыг хэн сэргээх вэ?

Үндсэн Хуулийн Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж, УИХ-д өргөн барьсан МУ-ын Ерөнхийлөгч Х. Баттулгын саналтай холбогдож олон нийт эгдүүцлээ илэрхийлж байсан. Улмаар Ерөнхийлөгч саналаа эргүүлэн татсан захирамж гарсан тухай 2017 оны 10-р сарын 12-ны өдөр хэвлэлээр мэдээлжээ. Цэцийн гишүүний асуудалд олон нийт ихээр анхаарал тавьж байгааг өнгөрсөн жилүүдэд улам хурцдсан Цэц ба УИХ хоёрын хоорондын ил цагаандаа гарсан зөрчилдөөнөөр тайлбарлаж болох юм. Энэхүү нийтлэлээр Цэцийн эрх мэдэл, бодит нөлөөний асуудлыг хөндье.

Цэц нь Үндсэн хуулийн шүүх болох нь

Цэц нь МУ-ын Үндсэн хуулийн хяналтын байгууллага юм. Цэцийг шүүх мөн эсэх тухай өнгөрсөн 25 жилийн туршид нэлээд маргаж, мэтгэлцэж иржээ.

Цэцэд холбогдох хуулиудын дагуу маргаан шийдвэрлэх хэд хэдэн арга зам байдаг. Гэвч зарим нэг маш цөөн тохиолдлыг эс харгалзвал өнгөрсөн хугацаанд Цэцэд дан ганц иргэний өргөдөл, мэдээллээр л маргаан шийдвэрлэж иржээ гэдэг нь 2016 онд нийтлэгдсэн судалгаанаас харагдаж байна.¹ Чингэхдээ МУ-ын Дээд Шүүхээс 1992 оноос хойш зургаан удаа л Цэцэд хүсэлт гаргаж хандсан байна.

Монголын судлаачид монголын Үндсэн хуулийн төслийг боловсруулахад Герман, Австри, Францын загваруудыг судалж үзсэн, Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог Австрийн загвараас санаа авч бүтээсэн гэж заримдаа бичиж, ярьдаг. Энэ нь зарим нэг жижиг зүйлийн хувьд үндэстэй хэдий ч Үндсэн Хуулийн Цэцэд иргэн өргөдөл, мэдээлэл гаргаж хандах, Улсын Дээд Шүүх Цэцэд хүсэлт гаргаж хандах ажиллагаа нь эдгээр орнуудынхаас тэс ондоо юм. Амьдрал дээр Цэц нь УИХ ба ЗГ эсвэл ЗГ ба аймгуудын хоорондох маргааныг шийдвэрлэдэггүй. Үүний дээр Цэц нь гомдол гаргагч иргэний үндсэн эрх зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуульд нийцээгүй шүүхийн шийдвэрийг цуцалж, холбогдох шүүхэд дахин шийдвэрлүүлэхээр буцаадаггүй. Герман, Австрийнхтай ойролцоо хувь хүн гомдол гаргах ажиллагаа Цэцэд явагддаггүй.

Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах

Иргэд Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах үйл ажиллагааг Европын хуульчдын нүдээр харвал ойлгоход нэлээд хэцүү юм. Үүнийг ойлгохын тулд Европын хуульчид төлөөллийн ардчилал, парламентийн

бүрэн эрх төдийгүй шүүхийн хамгаалал гэсэн уламжлалт ойлголтоо тархинаасаа авч хаяад үүний оронд Европт байдаг шиг парламентийн өргөдлийн байнгын хороог төсөөлж бодох хэрэгтэй юм. Чингэхдээ өргөдлийн байнгын хороо нь парламентийн гадна байдаг гэдгийг төсөөлөлдөө багтаах хэрэгтэй юм.

Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг иргэний өргөдөл, мэдээллээр явуулдаг. Иргэд Цэцэд өөрийн болон гэр бүлийнх нь гишүүний эрхтэй холбоотой өргөдөл гаргаж болно. Өөрийнх нь эрх ашгийг хөндөөгүй асуудлаар ч иргэд Цэцэд хандаж, нийтийн эрх ашгийн төлөө мэдээлэл гаргаж болдог. Дээр дурдсан 2016 оны судалгаагаар өнгөрсөн 25 жилийн хугацаанд иргэд Цэцэд УИХ-аас баталсан хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн гэж гол төлөв ханджээ.

УИХ-аас хууль батлах шатанд тухайн хуулийн төсөл нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Цэц шалгадаггүй. Иймээс Цэц нь зарчмын хувьд УИХ-аас баталж, хүчин төгөлдөр болсон хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянадаг.

Цэцэд иргэний өргөдөл, мэдээллээр маргаан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн бол Цэц нь эхлээд хуулийн заалт Үндсэн хуульд нийцэж байгаа тухай дүгнэлт гаргадаг. Үндсэн хууль зөрсөн гэж дүгнэлт гаргавал тухайн хуулийн заалтын үйлчлэлийг эхний ээлжинд түдгэлзүүлдэг. Үүний дараа УИХ нь Цэцийн дүгнэлтийг зарчмын хувьд 15 хоногийн дотор хэлэлцэж, шийдвэрлэх ёстой байдаг. Цэцийн дүгнэлтийг УИХ зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг Цэц хэлэлцэж, эцсийн шийдвэр буюу тогтоол гаргадаг ба ингэхдээ Цэц нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хуулийн заалтыг хүчингүй болгох эрхтэй байдаг.

Цэц ба УИХ хоорондын харилцаа

Цэц нь парламентийн гадна байх, хууль хүчингүй болгох эрхтэй өргөдлийн байнгын хороо шиг ажилладаг одоогийн тогтолцооны өгөгдлөөс харахад л Цэц ба УИХ-ын харилцаа нь төвөгтэй, хэцүү байх нь ойлгомжтой байна. УИХ нь хуульд заасан 15 хоногийн хугацааг мөрдөхгүй байх нь нийтлэг төдийгүй Цэц нь 25 жилийнхээ түүхэнд 59 маргааны хувьд л эцсийн шийдвэр гаргасан гэж дээрх судалгаанд дурьджээ. Үүний дээр Цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон зүйл, заалттай яг ижил заалттай хуулийг УИХ дахин баталсан байхыг судалгаанд жишээ татаж харуулжээ. Ингэхээр бодит амьдрал дээр Цэцийн эрх мэдэл, нөлөө бага юм.

Эргэцүүлэл

Монголын төр санхүү мөнгөний байнгын гачигдалтай байдаг, туйлын ядуу амьдралтай хүмүүс маш их байгаа өнөөгийн өнцгөөс харвал асуудал хэн хүний бухимдлыг төрүүлэхүйц ажээ. 25 жилийн туршид 59 эцсийн шийдвэр гаргасан бөгөөд ийм шийдвэрийг нь ч УИХ хүндэтгэж үздэггүй байгууллагын гишүүд, ажилчид, ордон байрны зардлыг ядуу монголчууд яагаад төлөх ёстой юм бэ? Үүний дээр Хүний эрхийн Үндэсний Комисс гэж төрөөс санхүүждэг байгууллага байдаг төдийгүй төр Улсын Дээд Шүүх болон бусад шүүхүүдийг ч санхүүжүүлдэг.

Цэц яагаад хууль хүчингүй болгох эрхтэй байгаа юм бэ? Монголын ард түмэн өөрсдийн элч, төлөөлөгчийг УИХ-д илгээсэн бус уу? 76 гишүүнтэй УИХ-аас баталсан хуулийг Цэцийн есөн гишүүн хүчингүй болгох нь зөв үү? Цэцэд “нийтийн эрх ашгийг” хамгаалах нэрээр мэдээлэл гаргаж байгаа “идэвхтэй” иргэд маань үнэхээр олон нийтийн төлөө яваад байна уу? Үнэхээр тийм бол тэд өөрт нь тулаагүй “бусдын” асуудлыг ухаж ойлгох чадвартай байх уу? Өнөөдөр Монгол улс банк санхүү, өмч хөрөнгө, гэрээ хэлцлийн нэн төвөгтэй сүлжээнд орсон орчин үеийн эдийн засагтай болсон байна. Энэ тогтолцоонд холбогдох олон сүлжилдсэн эрх ашгийг сайн санаат мэдээлэл гаргагч иргэн маань ойлгож ухах чадвартай юу? Ер нь Цэц өөрөө ч ийм нөхцөлд шийдвэр гаргах чадвартай, процестой юу? УИХ-аас баталсан хуулийг өм цөм, энд тэндээс нь түдгэлзүүлж, хүчингүй болгоод хуулиа ойлгох, хэрэглэх боломжгүй болохгүй байх баталгаа байна уу? Ийм замаар Цэц өөрөө эрх зүйн баталгаат бус, ойлгомжгүй байдалд хувь нэмэр оруулаад байна уу?

МУ-ын Ерөнхийлөгч Х. Баттулга нь сонгогдоод удаагүй тул олон түмний дэмжлэгийг хадгалж үлдэх сонирхолтой байх нь зүйн хэрэг юм. Ингэхээр Цэцийн гишүүнээр хэнийг санал болгох вэ? гэдэг асуудал нь өнөө маргаашдаа Ерөнхийлөгчийн хувьд чухал байх нь зайлшгүй. Харин алс ирээдүйгээ бодвол суурь үнэт зүйл, үнэт зарчим бүтээж чадах, иргэд ба бизнес эрхлэгчдийг төрийн дур зоргоор авирлалтаас хамгаалж чадах Үндсэн хууль, энэрэнгүй ёсыг сэргээх, манах шинэ тогтолцоог бүтээх асуудалд шийдэл олох зайлшгүй хэрэгтэй болжээ.

¹Энхбаатар ба бусад, Монгол Улсын 1992 оны Үндсэн Хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, 2016 он, www.mn.undp.org



Дефакто Тойм

Ням гараг бүр, 19:00 цагаас
VTV, Facebook Live

2017.10.22

I. ЯДУУРЛЫН ТҮВШИН ӨСЧЭЭ.

II. УИХ-ААР ЗГ-ЫН ГИШҮҮДИЙГ БАТАЛЛАА.

III. ЕРӨНХИЙЛӨГЧ Х БАТТУЛГА ЦААЗЫН
ЯЛЫГ СӨХӨЖ ТАВИЛАА.IV. САГСАН БӨМБӨГИЙН АЗИЙН АВАРГЫН
ТЭМЦЭЭН БОЛНО.

ЯДУУРЛЫН ТҮВШИН ӨСЧЭЭ

Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо, Дэлхийн банктай хамтраад “Ядуурлын түвшин – 2016” хэмээх 2 жил тутамд хийгддэг судалгааг хийсэн байна.

Судалгааны үр дүнгээс харахад Монгол улсын ядуурлын түвшин өмнөх жилүүдээс өссөн байгаа буюу хүн амын 29.6 хувь нь ядуурлын түвшинд байгаа нь харагдаж байгаа юм.

Энэ удаагийн судалгааны гол онцлог нь аймаг тус бүрээр ядуурлын түвшинг гаргасан бөгөөд Өмнөговь аймаг ядуурлын түвшин хамгийн бага, Говьсүмбэр аймаг хамгийн их гэж тогтоогджээ.

Ядуурлын түвшинг хэрхэн хэмжих, ямар хүнийг ядуу гэх вэ гэдэг дээр олон улсын байгууллагын тогтсон аргачлал байдаг. Нэг хүний нэг сард амьжиргааны наад захын хэрэглээний зардал нь 146 мянган төгрөгөөс бага байгаа бол тэр хүнийг ядуу гэж үздэг. 2 жилийн өмнө ч энэ дүнгээр тооцсон байтал 2 жилийн өмнөхөөс 300 мянган хүн нэмж ядуурлын түвшин рүү буусан байгаа юм. Нийт хүн амын 45.2 хувь нь Улаанбаатар хотод амьдардаг, гэтэл үүний 37.8 хувь нь буюу ойролцоогоор 5 хүний 2 нь ядуу байна гэж гарсан. Төвийн бүс нутгаар 26.6%, баруун бүс, зүүн бүсээр 43% нь ядуу байна гэж судалгаагаар тогтоогджээ. Нэг хүний сарын хэрэглээ 146 мянган



Гэрэл зургийг undesten.mn

ДЕФАКТО ТОЙМ

Долоо хоног бүрийн тойм, jargaldefacto.com/category/12

Ням гараг бүр VTV-ээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.10.22-ны дугаар

төгрөгөөс бага байгаа нь хоол хүнс, калори, тэжээл зэргээ хангахуйц бус байгааг нь илтгэж байгаа юм. Монгол улс 2030 он гэхэд ядуурлыг арилгана гэж аль хэдийн дэлхийд гарын үсгээ зурчихсаны хувьд энэ тоо бол маш ноцтой тоо баримт байгаа юм.

Өмнө нь хүн амын 20% энэ түвшнээс доогуур байсан боловч өнөөдөр 29.6% болж 9.6%-аар буюу 300 мянган хүнээр нэмэгдсэн байна. Үүний шалтгаан нь мэдээж ажилгүйдэл, мөн эдийн засгийн бодлогын асуудал байдаг. Монгол улсын үе үеийн Засгийн газар ядуурлыг бууруулах тухай ярьдаг боловч бууруулах хэлбэрээ сонгож байгаа нь өөрөө учир дутагдалтай. Голдуу халамжийн мөнгө өгөх бодлого зохиодог ба үнэхээр хоолгүй хүнд хоол өгөх нь зүйтэй ч хоолтой хүнд ажилд орох боломжийг хангах нь зүйтэй юм. Гэвч ажлыг хувийн хэвшил олгодог, харин сая татвар нэлээд нэмсэнээр хувийн хэвшил ажилтан авах нь хэцүү болсон юм. Хүн ажилд авна гэдэг нь түүний нийгмийн холбогдолтой зардлыг ажил олгогч төлдөг боловч зүй нь бол ажилчин хүн өөрөө цалингаа аваад төлөх юм. Монгол улсад 850 мянган хүн яг энэ маягаар татвараа төлдөг секторт ажилладаг, 300–400 мянган хүн албан бус болох саарал эдийн засагт ажилладаг, үүний 130 мянга нь бичил уурхай буюу нинжа болж амьдралаа залгуулж байна. Энэ бүхэн бол хүн амьдрахын тулд бүх хүчээрээ, дөрвөн мөчөөрөө л тэмцэж байгаа ч үр дүн бага байна гэсэн үг л дээ. Хүн амын 3-ны 1 нь ядуу байна гэдэг маш ноцтой, хүлээн зөвшөөрч болохгүй тоо бөгөөд үүнтэй маш яаралтай тэмцэх хэрэгтэй.

Энэ бүхэн эдийн засаг зогсонги байдалтай болсонтой холбоотой ба төр засаг нь гадаад дотоодын өрөнд баригдсан учраас зогсонги

байдалд ороод байна. Яагаад өрөнд баригдсан шалтгаан нь авсан зээлээ хаана хийснээ мэдэхгүй, хариуцлага тооцож чадахгүй, авсан хүн нь буцааж өгөхгүй байхаар аваагүй хүн нь өмнөөс нь төлж байна. Ийм учраас бид ядуурч байна. Энэ бүхний цаана хамгийн хийж чадахгүй байгаа зүйл нь шударга ёс юм. Засгийн газар урьд авсан зээлүүдээс нэгийг ч төлөлгүй тэрнээс илүү зээл авч, өмнөх зээлээ хаагаад байгаа. Өрөнд орох тусмаа эргээд ард иргэдийг зумлах, чарлуулахгүйгээр өдийг нь зулгаах бодлого явуулдаг. Энэ бодлого улмаар тогтворгүй байдлыг бий болгоно гэж харж байна.

УИХ-ААР ЗГ-ЫН ГИШҮҮДИЙГ БАТАЛЛАА



Гэрэл зургийг zasag.mn

УИХ шинэ Засгийн газарт багтах сайд нарыг баталлаа. Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зүгээс Сангийн яамны сайдад нэр дэвшигчийг дэмжихгүй гэдгээ илэрхийлсэн ба Ардчилсан намын зүгээс голлох чиг үүргийн яамдын сайд нараас бусдыг дэмжих боломжгүй гэдгээ илэрхийлсэн. Гэсэн хэдий ч УИХ бүх сайдыг томилон баталсан.

Энэ удаагийн Засгийн газрыг байгуулах зарчим нь, суурь бүтэц нь өөрчлөгдөөгүй. Бүгд л УИХ-ын гишүүд. МАН дотроо хоёр хэсэгт хуваагдаад харилцан тохиролцож засгийн газраа арай чүү байгуулж байна.

Сайд нарын нэрийг хүн бүрээр батална гэдэг өөрөө Ерөнхий сайдын эрх мэдлийг хязгаарлаж байгаа гэсэн үг. Ер нь ч тэгээд асуудлыг шинэ Засгийн газар, шинэ сайдууд шийднэ гэж ойлгох нь буруу. Өчигдөр би Энэтхэгийн төрийн албаны холбооны комиссын дарга профессор Д.Суймлэ гэж хүнтэй Дефакто ярилцлага хийхэд энэтхэгт төр солигдоход сая гаруй төрийн албан хаагч нэг нь ч солигдолгүй зөвхөн төрийн сайд л солигддог байна. Төрийн аппаратыг сольдоггүй ба одоогийн энэтхэгийн төрийн алба 1900-аад оны эхээр Англичуудын байгуулсан алба юм. Тэрхүү албанд төрийн нарийн бичгийн дарга хүн дунджаар 30 жил ажилласан хүн байдаг ба үнэхээр мэдлэг, чадвараараа тэргүүлэн тэрхүү албыг хашдаг юм байна. Энэтхэг ардчилсан замаар улс орноо авч яваад байгаа суурь шалтгаан нь төрийн буюу нийтийн албаны хүмүүсийнх нь чадварт оршдог юм байна. Харин манайд шинэ засгийн газраар хомроглон бүгдийг сольж эхэлдэг ба үүний үр дүнд төрийн үйлчлэх чадвар мууддаг.

У.Хүрэлсүх Ерөнхий сайд өөрийгөө ЗГ-ын 50% гэж илэрхийлсэн ч бодит байдал тийм биш юм. Ерөнхий сайд сайд нараа халж, дүгнэж, аль эсвэл шинээр авах боломжгүй болсон. Мөн сонирхолтой нь Монгол улсын бүх сайд нар Ерөнхий сайдаасаа өндөр албан тушаалтай буюу хууль тогтоогчид. Тэд бүгд давхар дээлтэй, харин Ерөнхий сайд ганц дээлтэй. Хууль зүйн талаас эрх мэдлийн статусыг үзвэл Ерөнхий сайд хамгийн доор нь байгаа. Энэ нь шинэ Ерөнхий сайдын маш том сорилт болж байгаа бөгөөд, залуу хүн тул тун эрчтэй байгаа нь харагдаж байна. Хамгийн гол нь шинэ Ерөнхий сайд, Ерөнхийлөгчөөс Монгол улс шударга ёсыг л хүлээж байгаа. Монгол улсын Ерөнхийлөгч шинэ Сангийн сайдад нэр дэвшсэн Ч.Хүрэлбаатарыг дэмжихгүйгээ илэрхийлсэн ч УИХ баталсан нь Ерөнхийлөгч хязгаарлагдмал эрх

мэдэлтэй гэдгийг харуулж байгаа. Хуулийн дагуу бол Ерөнхийлөгч тийм ч том эрх мэдэлтэй биш.

Бид Засгийн газар, яамдын үүргийг сайн салгаж ойлгох хэрэгтэй байгаа. Төрийн үүрэг ердөө 3 л байдаг.

1. Иргэдийн амь нас, аюулгүй байдлыг,

2. Иргэдийн эрх, эрх чөлөөг,

3. Иргэдийн болон нийтийн хөрөнгийг хамгаалах ёстой байдаг. Энэхүү гурван үүргийг л наад зах нь сайн биелүүлэх ёстой. Тэгэхийн тулд тодорхой стандарт тавиад, түүнийгээ төрийн ч хувийн ч хэвшлийн бүх хүмүүс мөрдөх ёстой байгаа юм. Мөн хувийн салбар ажил олгох бүх юмыг хийх ба төр харин хувийн салбарын хийж чадахгүй байгаа батлан хамгаалах, дэд бүтэц зэрэг зүйлсийг хийх ёстой.

Одоо сайдууд бүгд л өөрийн гэсэн бизнестэй, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах эсэх асуудлыг иргэд нийтээрээ хянах ёстой. Бусад оронд бол бүх бизнесээсээ гарсан гэсэн гарын үсэг зурж, төлөөний хүнээ тавьж явдаг.

ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА ЦААЗЫН ЯЛЫГ СӨХӨН ТАВИЛАА

Ерөнхийлөгчийн албан ёсны вэбсайтад мэдээлсэнээр МУ цаазын ялыг халах түвшинд хүртлээ хөгжөөгүй буюу хувь хүн нь төлөвшиж, нийгэм тогтворжсон үед цаазын ялыг халах ёстой. Тиймээс хуульчдын баг гаргаж энэ асуудлыг судлуулж байна гэжээ.

МУ 2012 оноос цаазын ялаас



Гэрэл зургийг news.mn

түдгэлзсэн бөгөөд 2015 онд батлагдаж 2017 оны 7 сарын 01 –нээс хэрэгжиж эхэлсэн эрүүгийн хуулиар цаазын ял гэсэн ялын төрлийг хассан. Монгол улсын Ерөнхийлөгч гэдэг нийгмийн эв нэгдлийг хамгаалсан хамгийн дээд албан тушаал юм.

Хохирогчийн зүгээс аваад үзвэл өөр сонголтгүй болоод байгаа ч нийгэм төлөвшихгүй байгаагийн шалтгаан нь хүн алсан хүнийг алахгүй байгаадаа байна уу, эсвэл ядуурал байгаадаа байна уу гэдгийг нарийн судлахгүй бол цөөхөн тохиолдлоос том асуудлыг шийддэггүй. Цаазын ялыг сэргээснээр хүчирхийллийг зогсоож чадах уу үгүй юу гэдэг улс орныг хуваадаг том асуудал юм. Нэг талаас хүний айдсыг төрүүлж байгаа тул хүчирхийллийг зогсооно гэж хүмүүс бодож байгаа. Энэ тухай маш сонирхолтой судалгаа үзэхэд АНУ-ын Dartmouth коллежийн профессор ноён Жон Ламберти 2010 онд судалгаа хийхэд 1973-аас 1984 оны хооронд 11 жилийн турш АНУ –ын цаазын ялтай болон цаазын ялгүй 50 мужийн гэмт хэргүүдийг судлаад цаазын ялтайд их үү, цаазын ялгүйд их үү гэтэл цаазын ялтай мужуудад 100 мянган хүн тутамд 5.2 хүн амины хэрэг гарсан ба цаазын ялгүй мужид 3.3 байсан байна.

Энэ 10 жилийн туршлагаас харахад цаазын ялтай байсан ч бага хүн амины гэмт хэрэг гараагүй байгаа нь харагдаж байна. Энэ дүн бараг 65%-аар бага байгаа бөгөөд заавал цаазын ялтай байж хүн амины хэргийг таслан зогсооно гэдэг энэ жишээгээр үгүйсгэгдэж байгаа юм. Тиймээс Дефакто мэтгэлцээний дараагийн дугаарыг энэ сэдвээр хийнэ гэж төлөвлөөд байна.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-1sh-22> холбоосоор үзнэ үү.